


UCS 0304B:2025

ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ХОТ БАЙГУУЛАЛТ




Улаанбаатар хотын зуслангийн бүс, улсын тусгай
хамгаалалттай газар нутгийн зэрлэг амьтдад ээлтэй
хашаанд тавих ерөнхий шаардлага

ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ХОТ БАЙГУУЛАЛТ

Улаанбаатар хотын зуслангийн бүс, улсын тусгай
хамгаалалттай газар нутгийн зэрлэг амьтдад ээлтэй
хашаанд тавих ерөнхий шаардлага

*Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 25/05-р тогтоолоор батлав.*



ГАРЧИГ

1. Хамрах хүрээ	4
2. Норматив эшлэл	4
3. Нэр томъёо ба тодорхойлолт	5
4. Зуслангийн бүсийн зэрлэг амьтдад ээлтэй хашааны ерөнхий шаардлага	5
5. Зуслангийн бүсийн зэрлэг амьтдад ээлтэй хашааны техникийн шаардлага	5
5.1 Төмөр утсан хөндлөвчтэй хашаа	5
5.2 Босоо шугаман хашаа	9
5.3 Экологийн хашаа	10
6. Тусгай шаардлага	11
7. Тусгай хамгаалалттай газар нутгийн зэрлэг амьтдад ээлтэй хашааны ерөнхий шаардлага	12
8. Тусгай хамгаалалттай нутгийн зэрлэг амьтдад ээлтэй хашааны техникийн шаардлага	12
8.1 Хөндлөвчтэй хашаа	12
8.2 Босоо шугаман хашаа	14
8.3 Буулгадаг хашаа буюу гарц	15
8.4 Экологийн хашаа	16
9. Тусгай шаардлага	17
10. Шалгах хуудас	17
Ашигласан материал	19

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төмөр утсан хөндлөвчтэй хашаа	6
Зураг 2. Хөндлөвч утасны тохиргоо	7
Зураг 3. Хашааны тулгуур шонгийн суурь	8
Зураг 4. Налуу газрын шонгийн суурилуулалт	9
Зураг 5. Босоо шугаман хашаа	9
Зураг 6. Хайлаас шигүү тарьж ургуулсан экологийн хашаа	10
Зураг 7. Хашааны хөндлөвч төмөр утсанд ашигласан уян тууз	11
Зураг 8. Хөндлөвчтэй хашаа	12
Зураг 9. Буулгадаг хашаа	15
Зураг 10. Буулгадаг хашаа	16

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Шалгуур үзүүлэлт	17
Хүснэгт 2. Шалгуур үзүүлэлт	18



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 25/05

Улаанбаатар хот

Хот төлөвлөлт, хот байгуулалтад
хамаарах хотын стандартыг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт; Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10¹.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн “Хот төлөвлөлт, хот байгуулалт” бүлэгт хамаарах дор дурдсан хотын стандартуудыг хавсралтаар баталсугай.

1.1. UCS0302B:2025 “Оршуулгын газрын орчны эрүүл, аюулгүй байдлын ерөнхий шаардлага” хотын стандартыг нэгдүгээр хавсралтаар;

1.2. UCS0303B:2025 “Нийслэлийн ундны усны эх үүсвэрийн хамгаалалтад тавигдах шаардлага” хотын стандартыг хоёрдугаар хавсралтаар;

1.3. UCS0304B:2025 “Улаанбаатар хотын зуслангийн бүс, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн зэрлэг амьтдад ээлтэй хашаанд тавих ерөнхий шаардлага” хотын стандартыг гуравдугаар хавсралтаар;

2. Батлагдсан хотын стандартыг олон нийтэд сурталчлан, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолыг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүсчилсэн хөгжлийн хороо (Л.Ариунтуяа)-д даалгасугай.

ДАРГА



А.БАЯР

17.06.25

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн
дугаар тогтоолын гуравдугаар хавсралт

ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ХОТ БАЙГУУЛАЛТ

UCS 0304B:2025

“УЛААНБААТАР ХОТЫН ЗУСЛАНГИЙН БҮС, УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ЗЭРЛЭГ АМЬТДАД ЭЭЛТЭЙ ХАШААНД ТАВИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА” ХОТЫН СТАНДАРТ

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандарт нь Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт хамаарах зуслангийн бүс, улсын тусгай хамгаалалттай газар нутагт холбогдох хууль эрх зүйн хүрээнд зэрлэг амьтдад ээлтэй хашааг барих, ашиглах шаардлагыг тогтооно.

Энэхүү стандартыг тухайн газрыг эзэмшигч, өмчлөгч, ашиглагч, иргэн аж ахуйн нэгж дагаж мөрдөнө.

Энэхүү стандарт нь төмөр зам, авто зам, шугаман дэд бүтцийн хамгаалалтын хориг хашаа, газар тариалангийн талбайн хашаанд хамаарахгүй.

2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандарт нь эш татсан дараах хууль, стандартын шаардлагыг бүрэн хангах бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалыг үндэслэл болгоно.

- Байгаль хамгаалах тухай хууль, 1995;
- Амьтны тухай хууль, 2012;
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, 1994;
- MNS 6735:2018 Уулархаг нутгийн зам, замын байгууламжийн нүүдлийн зэрлэг амьтдад зориулсан гарц. Ерөнхий шаардлага;
- MNS 3736:2010 Хамгаалалтын төмөр бетон хашаа. Техникийн шаардлага;
- MNS 2228:2019 Угсармал бетон, төмөр бетон бүтэц эдлэхүүн. Техникийн ерөнхий шаардлага;
- MNS ISO 404:2003 Ган ба ган бүтээгдэхүүн. Нийлүүлэх техникийн ерөнхий шаардлага;
- MNS JIS G 3532:2006 Бага нүүрстөрөгчит ган утас;
- MNS 4931:2000 Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэл Ерөнхий шаардлага, ангилал;
- MNS 4244:1994 Хөдөлмөр хамгааллын систем Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага;
- MNS 5566:2020 Аж ахуйн нэгж байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм;
- UCS 1410B:2022 Хашаа, хайс, хашлаганд тавих ерөнхий шаардлага;
- UCS 1902B:2022 Гэрэлтүүлэгт тавих ерөнхий шаардлага.

3. НЭР ТОМЬЁО БА ТОДОРХОЙЛОЛТ

Зуслангийн бүс - гэж нийслэлийн иргэд зуны улиралд түр хугацаагаар суурин амьдарч болох, Улаанбаатар хотын төвөөс зайдуу орших төвлөрсөн дэд бүтэцгүй суурьшлын газар нутаг;

Тусгай хамгаалалттай газар нутгийн бүс - гэж дархан цаазат болон байгалийн цогцолборт газрын байгалийн хэв шинжийг төлөөлөх онцлог, ховор, нэн ховор амьтан, ургамал, түүх, соёлын дурсгалт зүйлийн байршлыг харгалзан тогтоосон өөр өөр хамгаалалтын дэглэм бүхий газар нутаг;

Хашаа - гэж гадна талбайг хязгаарлах буюу хуваах, ихэвчлэн хөнгөн жинтэй даацын бус босоо хийц;

Экологийн хашаа - гэж зэрлэг амьтдад ээлтэй, тэдгээрийн шилжилт хөдөлгөөн чөлөөтэй нэвтрэх боломжийг бий болгох зорилгоор мод, бут, сөөглөг ургамлыг дангаар болон хослуулан тарьж шигүү ургуулсан ургамлан хашаа;

Хориг хашаа - гэж амьтны зүйлүүдийг дэд бүтцийн байгууламж руу нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах зориулалт бүхий, стандартын дагуу барьсан хаалт;

Зэрлэг амьтан - гэж монгол улсын нутаг дэвсгэрт байнга буюу түр нутагшсан хөхтөн, шувуу, мөлхөгч, хоёр нутагтан, загас, хавч хэлбэртэн, шавж, зөөлөн биетэн, эгэл биетэн болон мал, тэжээвэр амьтнаас бусад амьтан;

Амьтны нүүдэл - гэж зэрлэг амьтдын төллөх, үр төлөө өсгөх, ороо хөөцөөнд орох зэргээр амьдрах тохиромжтой нутгаа улирлаар сольж байрших үйл явц;

Амьтны шилжилт хөдөлгөөн - гэж зэрлэг амьтад идэш тэжээлээ хайх, цаг уурын тааламжгүй нөхцөлөөс зугтах зэргээр байршлаа богино хугацаанд (хоногоор) солих үйл явц.


4. ЗУСЛАНГИЙН БҮСИЙН ЗЭРЛЭГ АМЬТДАД ЭЭЛТЭЙ ХАШААНЫ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 4.1 Улаанбаатар хотын зуслангийн бүсэд зэрлэг амьтдын аюулгүй байдлыг хангасан, амьтанд ээлтэй хашааг ашиглана.
- 4.2 Зэрлэг амьтдад ээлтэй хашааны байршлыг тухайн орон нутгийн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно.
- 4.3 Улаанбаатар хотын зуслангийн бүсэд байршуулсан хашаанаас хамааран түгээмэл хорогддог ойн хөхтөн амьтад болох халиун буга, бор гөрөөс, болон бусад амьтдын нүүдэл, шилжилт хөдөлгөөний зам, өвөл, зуны байршил нутгийг тодорхойлохдоо сансрын дохиололтой хүзүүвч, автомат камер, ул мөрийн судалгаа, газар зүйн мэдээллийн систем, зайнаас тандан судлал, иргэдийн оролцоотой мониторинг зэрэг судалгааны арга зүйг дангаар болон хослуулан ашиглана.
- 4.4 Зуслангийн бүсийн хашааг гол нуур, ойн сан бүхий газраас 200м-ээс доошгүй зайд барина.
- 4.5 Улаанбаатар хотын зуслангийн бүсийн зэрлэг амьтдад ээлтэй хашаа нь тухайн зүйл зэрлэг амьтдын зан төрх, биеийн хэмжээнд тохирсон, тэдгээрт аюул, гэмтэл учруулахгүй байх хэмжээ, хийц, загвар, материалын сонголттой байна.

5. ЗУСЛАНГИЙН БҮСИЙН ЗЭРЛЭГ АМЬТДАД ЭЭЛТЭЙ ХАШААНЫ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

5.1 ТӨМӨР УТСАН ХӨНДЛӨВЧТЭЙ ХАШАА

- 5.1.1 Хашаа нь тулгуур шон, хөндлөвч төмөр утас, бэхэлгээ гэсэн бүрдэл хэсэгтэй байна.



Зураг 1. Төмөр утсан хөндлөвчтэй хашаа (жишээ зураг)

5.1.2 Төмөр утсан хөндлөвчтэй хашааны хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- хашааны тулгуур шонд төмөр утсыг хөндлөн бэхлэх байрлал 3 эгнээ байна;
- тулгуур шонгийн өндөр нь газрын тэгш гадаргуугаас 1200мм-ээс ихгүй байна;
- тулгуур шон хоорондын зай хашааны өнцгөөс бусад хэсэгт 1800мм-ээс багагүй байна;
- тулгуур шонг суулгах гүн газрын гадаргаас доош 500мм-ээс багагүй байна;
- хашааны шон нийт уртын дагуу босоо тэнхлэгээсээ хазайх хазайлтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ 3,0см/м-ээс ихгүй байна;
- хамгийн дээд эгнээний хөндлөвч төмөр утас ба тулгуур шонгийн орой хоорондын зай 50мм-ээс багагүй байна;
- хамгийн дээд болон дунд эгнээний хөндлөвч төмөр утасны хоорондын зай 300мм-ээс багагүй байна;
- хамгийн доод эгнээний хөндлөвч төмөр утас ба шонг суурилуулсан газрын гадаргуугийн хоорондын зай 450мм-ээс багагүй байна;
- хөндлөвч төмөр утасны голч 5-10мм байна.
- хөндлөвч төмөр утасны суналтын бат бэх нь 0,25-0,27 г/м²-аас багагүй байна;
- мод эсвэл ган хоолойгоор хийсэн тулгуур шонгийн голч 50-70мм байна;
- квадрат төмөр эсвэл бетонон шонгийн хөндлөн огтлол 150х150мм-ээс багагүй байна.


5.1.3 Хашааны материал нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- хашааны тулгуур шонг мод, төмөр, бетон материалаар хийж болно;
- хашааны хөндлөвчид сүлжмэл бүрээстэй болон бүрээсгүй төмөр утас ашиглана;

- хашааны материалд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зэрлэг амьтдад ээлтэй дэвшилтэт бусад материалыг хэрэглэж болно;
- зэрлэг амьтдад ээлтэй хашаанд өргөст төмөр утас болон хүчдэлтэй цахилгааны утас хэрэглэхийг хориглоно;
- цаг уурын эрс тэс хүйтэн, халууны үед физик, механик шинж чанарт өөрчлөлт орохгүй байх;
- химийн хүчин зүйлүүдэд бат бөх тэсвэртэй байх;
- гаднын нөлөөнд тэсвэртэй байх;
- 15м/с-ээс багагүй хурдтай салхинд тэсвэртэй байх;
- 1,5кН/м²-аас багагүй ус, цасны ачааллыг тэсвэрлэх чадвартай байх;
- ус зайлуулах сувагт саад учруулахгүй, элс, цасны хуримтлалыг нэмэгдүүлэхгүй байх;
- хашааны төмөр материал нь зэвэрдэггүй, цайрдмал байна;
- засвар үйлчилгээ хийх боломжтой байх.

5.1.4 Хашааны бэхэлгээ нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:


- хашааны хөндлөвч төмөр утсыг тулгуур шонд гүүр, үдээс, шруп зэрэг бусад бэхэлгээний эд анги ашиглан түгжиж бэхэлнэ;
- тухайн зэрлэг амьтны зүйл, биеийн хэмжээ, зан төрх харилцан адилгүй тул зэрлэг амьтдад ээлтэй хашааны төмөр утсыг тохируулах, өөрчлөх боломжтой түгжээг нэмэлтээр ашиглаж болно (Зураг 2).



Зураг 2. Хөндлөвч утасны тохиргоо (жишээ зураг)

5.1.5 Хашааны суурь нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:


- хашааны тулгуур шонг хөрсөнд суурилуулах суурийн нүхний гүн 500мм-ээс багагүй байна;
- хэрэв тулгуур шон нь төмөр эсвэл бетон бол шон суух суурийн нүхийг цементэн зуурмагаар дүүргэж бэхжүүлнэ (Зураг 3).
- хашааны суурь нь хашааны тулгуур шон хоорондын зайд 16кН-ын ачаалалд хашааны тогтвортой байдлыг хангасан байна;
- хашааны чиглэл өөрчлөгдөх хэсэгт байрлах булангийн тулгуур шонг хашааны гулзайлтын булангийн гадна талд байхаар суурилуулна.



Зураг 3. Хашааны тулгуур шонгийн суурь (жишээ зураг)

- 5.1.6 Хашаанд хоёр, гурав ба дөрвөн талаас нь тулах шонг ашиглаж болно. Тулах шонгийн хөндлөн огтлолын хэмжээ ба өргөн нь үндсэн шонгийн хэмжээтэй ижил байна.
- 5.1.7 Тулах шонг үндсэн тулгуур шонтой холбохдоо гагнаас, эрэг боолт болон бусад аргаар бэхэлнэ.


5.1.8 Хашаа байршуулах газрын налуугаас хамааран хашааны өндрийн хэмжээг тооцож суурилуулна. Газрын налуу ихсэх тусам зэрлэг амьтдын хашаан дээгүүр харайн гарах зай төдий чинээ нэмэгдэх тул тулгуур шонгийн өндрийг газрын тэгш гадаргуугаас 1200мм-ээс ихгүй, 30% налуу гадаргуугаас 900мм-ээс ихгүй, 50% налуу гадаргуугаас 600мм-ээс ихгүй зайд тус тус суурилуулна (Зураг 4).



Зураг 4. Налуу газрын шонгийн суурилуулалт (жишээ зураг) (Зургийг: Christine Paige)

5.2 БОСОО ШУГАМАН ХАШАА

5.2.1 Хашаа нь тулгуур шон, босоо шугаман багана болон хөндлөн хөндлөвч гэсэн бүрдэл хэсэгтэй байна (Зураг 5).



Зураг 5. Босоо шугаман хашаа (жишээ зураг)

5.2.2 Хашааны хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- тулгуур шонгийн өндөр нь газрын тэгш гадаргуугаас 1200мм-ээс ихгүй;
- тулгуур шон хоорондын зай хашааны өнцгөөс бусад хэсэгт 1800мм-ээс багагүй байна;
- хашааны өнцөг хэсэгт байрлах тулгуур шонд хашааны гулзайлтаас хамааран байрлуулах тулах шон 2-оос доошгүй байна;

- хамгийн доод эгнээний хөндлөвч ба тулгуур шонг суурилуулсан газрын гадаргуугийн хоорондын зай 450мм-ээс багагүй;
- босоо шугаман багана хоорондын зай 70мм-ээс ихгүй.

5.2.3 Хашааны материал нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- хашааны тулгуур шон, хөндлөн хөндлөвч болон босоо баганууд нь зэвэрдэггүй, цайрдмал төмөр, дахин боловсруулсан нийлэг материал, мод байна;
- хашааны хөндлөвчид төмөр утас, сүлжмэл бүрээстэй төмөр утас, дахин боловсруулсан нийлэг материал хэрэглэж болно;
- зэрлэг амьтдад ээлтэй хашаанд өргөст төмөр утас болон хүчдэлтэй цахилгааны утас хэрэглэхгүй.

5.2.4 Хашааны бэхэлгээ нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- хашааны хөндлөвч болон босоо багануудыг тулгуур шонд гагнах эсвэл эрэг боолтын тусламжтай бэхэлнэ.

5.2.5 Хашааны суурь нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- хашааны тулгуур шонг хөрсний шинж чанараас хамааран 600 мм хүртэлх гүнд суулгана;
- төмөр тулгуур шон суух суурийн нүхийг цементэн зуурмагаар дүүргэж бэхжүүлнэ.

5.3 ЭКОЛОГИЙН ХАШАА

5.3.1 Хашаа нь зэрлэг амьтдад ээлтэй, чөлөөтэй нэвтрэх боломжийг бий болгох зорилгоор мод, бут, сөөглөг ургамлыг дангаар болон хослуулан тарьж шигүү ургуулсан ургамлан хашаа байна (Зураг 6).



Зураг 6. Хайлаас шигүү тарьж ургуулсан экологийн хашаа (жишээ зураг)

5.3.2 Хашааны хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- экологийн хашааны өндөр 1000мм-ээс багагүй байна;
- ургамлыг суулгах эгнээ нэг ба түүнээс дээш байна;
- экологийн хашааны барилга, байгууламж, инженерийн шугамд ойртох зай, хэмжээ UCS 1410B:2022 Хашаа, хайс, хашлаганд тавих ерөнхий шаардлага стандартын заалтад нийцэх.

5.3.3 Хашааны материал нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- экологийн хашаанд харь зүйлийн бут, сөөг, мод ашиглахгүй;
- экологийн хашааг бусад зэрлэг амьтдад ээлтэй хашаатай хослуулан тарьж болно.

6. ТУСГАЙ ШААРДЛАГА

6.1. Зуслангийн бүсийн зэрлэг амьтдад ээлтэй хашааны хөндлөвч утас нь зэрлэг амьтдыг хашаан дээгүүр харайх буюу доогуур мөлхөж нэвтрэхэд аюулгүй, орооцолдохгүй, гэмтэж бэртээхгүй байх, тод сайн харагдахуйц байна.

6.2 Зэрлэг амьтад орооцолдох өндөр эрсдэлтэй хашааны хамгийн дээд талын хөндлөвч төмөр утсыг уян тууз болон бусад материалаар бүрэх, гэрэл ойлгодог пайз зүүх, өндөр суналттай утас ашиглах зэргээр зэрлэг амьтдад ээлтэй, аюулгүй байдал болон харагдах байдлыг нэмэгдүүлсэн байна (Зураг 7).



Зураг 7. Хашааны хөндлөвч төмөр утсанд ашигласан уян тууз

6.3 Хашааны шон, хөндлөвч зэрэг бүрдэл хэсгийн бүрэн бүтэн байдал, ойр орчим байрлуулсан тэмдэг, тэмдэглэгээнд тухайн газрыг эзэмшигч, өмчлөгч иргэн аж ахуйн нэгж хяналт тавьж энэ стандартын шаардлагыг хангах арга хэмжээ авна.

6.4 Хашааны ойр орчим зэрлэг амьтад орооцолдох, саад учруулах шон, төмөр утас болон бусад хог хаягдлыг зайлуулах арга хэмжээг авна.

6.5 Зуслангийн бүсийн зэрлэг амьтдад ээлтэй хашааны байршуулалт, ашиглалт, бүрэн бүтэн байдлыг 1-р хавсралтын дагуу шалгана.


7. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ЗЭРЛЭГ АМЬТДАД ЭЭЛТЭЙ ХАШААНЫ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 7.1. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт хамаарах Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн зэрлэг амьтдад ээлтэй хашааг зэрлэг амьтад ихээр хорогддог, нүүдлийн зам нь дайран өнгөрдөг байршлуудад судалгааны үр дүнд үндэслэн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр байршуулна.
- 7.2 Зэрлэг амьтдын нүүдэл, шилжилт хөдөлгөөний зам, өвөл, зуны байршил нутгийг тодорхойлохдоо сансрын дохиололтой хүзүүвч, автомат камер, ул мөрийн судалгаа, газар зүйн мэдээллийн систем, зайнаас тандан судлал, иргэдийн оролцоотой мониторинг зэрэг судалгааны арга зүйг дангаар болон хослуулан ашиглаж болно.

8. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ НУТГИЙН ЗЭРЛЭГ АМЬТДАД ЭЭЛТЭЙ ХАШААНЫ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

8.1 ХӨНДЛӨВЧТЭЙ ХАШАА

- 8.1.1 Хашаа нь тулгуур шон, хөндлөвч, бэхэлгээ гэсэн бүрдэл хэсэгтэй байна (Зураг 8). Хашааны тулгуур шонд төмөр утас эсвэл модыг хөндлөн байрлалаар 2-оос 3 эгнээгээр байрлуулан бэхэлнэ.



Зураг 8. Хөндлөвчтэй хашаа (жишээ зураг)

8.1.2 Хашааны хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Тулгуур шонгийн өндөр нь газрын тэгш гадаргуугаас 1200мм-ээс ихгүй.
- Тулгуур шон хоорондын зай хашааны өнцгөөс бусад хэсэгт 1800мм-ээс багагүй байна.
- Хашааны шон нийт уртын дагуу босоо тэнхлэгээсээ хазайх хазайлтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ 3.0см/м-ээс ихгүй байна.
- Хамгийн дээд болон дунд эгнээний хөндлөвчийн хоорондын зай 300мм-ээс багагүй байна.
- Хамгийн доод эгнээний хөндлөвч ба тулгуур шонг суурилуулсан газрын гадаргуугийн хоорондын зай 450мм-ээс багагүй байна.
- Хөндлөвч төмөр утасны голч 5-10мм, модон хөндлөвчний голч 15-20мм байна.
- Хөндлөвч төмөр утасны суналтын бат бэх нь 0.25-0.27г/м²-аас багагүй байна.
- Мод эсвэл ган хоолойгоор хийсэн тулгуур шонгийн голч 50-70мм байна.
- Квадрат төмөр эсвэл бетонон шонгийн хөндлөн огтлол 150х150мм-ээс багагүй байна.

8.1.3 Хашааны материал нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- тусгай хамгаалалттай газар нутгийн зэрлэг амьтдад ээлтэй хашааны тулгуур шонг мод, төмөр, бетон материалаар хийж болно.
- ташааны хөндлөвчид мод, төмөр утас, сүлжмэл бүрээстэй төмөр утас, дахин боловсруулсан нийлэг материал, олс хэрэглэнэ.
- тусгай хамгаалалттай газар нутгийн зэрлэг амьтдад ээлтэй хашаа нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зэрлэг амьтдад ээлтэй дэвшилтэт бусад материалыг хэрэглэж болно.
- зэрлэг амьтдад ээлтэй хашаанд өргөст төмөр утас болон хүчдэлтэй цахилгааны утас хэрэглэхгүй. Цаг уурын эрс тэс хүйтэн, халууны үед физик, механик шинж чанарт өөрчлөлт орохгүй байх.
- Химийн хүчин зүйлүүдэд бат бөх тэсвэртэй байх,
- гаднын нөлөөнд тэсвэртэй байх.
- 15м/с-ээс багагүй хурдтай салхинд тэсвэртэй байх.
- 1.5кН/м²-аас багагүй ус, цасны ачааллыг тэсвэрлэх чадвартай байх,
- ус зайлуулах сувагт саад учруулахгүй, элс, цасны хуримтлалыг нэмэгдүүлэхгүй байх.
- хашааны төмөр материал нь зэвэрдэггүй, цайрдмал байх,
- засвар үйлчилгээ хийх боломжтой байх.

8.1.4 Хашааны бэхэлгээ нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- хашааны тулгуур шонд хөндлөвч мод, төмөр утсыг гүүр, үдээс, шруп зэрэг бусад бэхэлгээний эд анги хэрэглэн бэхэлнэ.
- тухайн амьтны зүйл, биеийн хэмжээ, зан төрхөөс хамааран зэрлэг амьтдад ээлтэй хашааны үр нөлөө харилцан адилгүй тул хашааны хөндлөвч төмөр утсыг тохируулах, өөрчлөх боломжтой түгжээг нэмэлтээр ашиглаж болно.

8.1.5 Хашааны суурь нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:


- тусгай хамгаалалттай газар нутгийн зэрлэг амьтдад ээлтэй хашааны тулгуур шонг хөрсөнд суурилуулах суурийн нүхний гүн 500мм-ээс багагүй байна.
- хэрэв тулгуур шон нь төмөр эсвэл бетон бол шон суух суурийн нүхийг цементэн зуурмагаар дүүргэж бэхжүүлнэ.
- хашааны суурь нь хашааны тулгуур шон хоорондын зайд 16кН-ын ачаалалд хашааны тогтвортой байдлыг хангасан байна.
- хашааны чиглэл өөрчлөгдөх хэсэгт байрлах булангийн тулгуур шонг хашааны гулзайлтын булангийн гадна талд байхаар суурилуулна.
- хашааг хоёр, гурав ба дөрвөн талаас нь тулах шонг ашиглаж болно. Тулах шонгийн хөндлөн огтлолын хэмжээ ба өргөн нь үндсэн шонгийн хэмжээтэй ижил байна.
- тулах шонг үндсэн тулгуур шонтой холбохдоо гагнаас, эрэг боолт болон бусад арга ашиглан бэхэлнэ.
- хашаа байршуулах газрын налуугаас хамааран хашааны өндрийг тооцож суурилуулна.
- тулгуур шонгийн өндрийг газрын тэгш гадаргуугаас 1200мм-ээс ихгүй, 30% налуу гадаргуугаас 900мм-ээс ихгүй, 50% налуу гадаргуугаас 600мм-ээс ихгүй зайд тус тус суурилуулна.

8.2 БОСОО ШУГАМАН ХАШАА

- 8.2.1 Хашаа нь тулгуур шон, босоо багана болон хөндлөвчөөс бүрдсэн загвартай байж болно.
- 8.2.2 Хашааны хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- Тулгуур шонгийн өндөр нь газрын тэгш гадаргуугаас 1200мм-ээс ихгүй байна.
 - Тулгуур шон хоорондын зай хашааны өнцгөөс бусад хэсэгт 1800мм-ээс багагүй байна.
 - Хамгийн доод эгнээний хөндлөвч ба шонг суурилуулсан газрын гадаргуугийн хоорондын зай 450мм-ээс багагүй байна. Босоо шугаман багана хоорондын зай 70мм-ээс ихгүй байна.
- 8.2.3 Хашааны материал нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- хашааны тулгуур шон, хөндлөвч төмөр утас болон босоо ган багана нь зэвэрдэггүй, цайрдмал төмөр материал байна.
 - хашааны хөндлөвчид мод, төмөр утас, сүлжмэл бүрээстэй төмөр утас, дахин боловсруулсан нийлэг материал, олс хэрэглэнэ.
- 8.2.4 Хашааны бэхэлгээ нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- хашааны хөндлөвч болон босоо багануудыг тулгуур шонд гагнах эсвэл эрэг боолт ашиглан бэхэлнэ.
- 8.2.5 Хашааны суурь нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- Хашааны тулгуур шонг хөрсний шинж чанараас хамааран 600мм хүртэлх гүнд суулгана.

8.3 БУУЛГАДАГ ХАШАА БУЮУ ГАРЦ

- 8.3.1 Зэрлэг амьтдыг нүүдлийн үед гэмтэж бэртээхгүй, аюулгүй дамжин өнгөрөхөд зориулсан боломжтой гарц эсвэл буулгах зориулалтын хашаатай байна (зураг 9), (зураг 10).
- 8.3.2 Буулгадаг хашааг амьтан судлаачдын дүгнэлт, зөвлөмжийг харгалзан зэрлэг амьтдын нүүдэл, шилжилт хөдөлгөөний зам, гарцыг тодорхойлон байршуулна.
- 8.3.3 Буулгадаг хашаа цасны хунгар, элсний хуримтлал, хөрсний эвдрэл нурултуулалт үүсэх эрсдэлтэй хэсэгт байршуулахаар төлөвлөсөн бол гарц руу хөтлөх налуу үүсгэх, гулсалтыг бууруулах, хөрсийг тогтворжуулах, ургамалжуулах, элс хайргаар бэхжүүлэх зэрэг хамгаалах арга хэмжээ авна.
- 8.3.4 Хашааны хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- хашааны өндөр 1200мм-ээс ихгүй, Буулгадаг хашааны нийт урт 2000мм-ээс ихгүй байна.
 - хамгийн доод эгнээний хөндлөвч төмөр утас ба шонг суурилуулсан газрын гадаргуугийн хоорондын зай 450мм-ээс багагүй байна.
 - хашааны тулгуур шонд төмөр утсыг хөндлөн байрлалаар 3-аас 4 эгнээгээр байрлуулан бэхлэх.
 - нийт уртын дагуу 1-ээс 2 нэмэлт баганатай байх. Буулгадаг хашааны хөндлөвч төмөр утасны хэмжээ 8.1.1-д заасан шаардлагыг хангах.



Зураг 9. Буулгадаг хашаа (жишээ зураг)



Зураг 10. Буулгадаг хашаа (жишээ зураг)

- 8.3.5 Хашааны материал нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- буулгадаг хашааны нэмэлт багана нь модон болон төмөр материал байж болно.
 - Буулгадаг хашааны материал 8.1.2-т заасан материалын шаардлагыг хангана.
- 8.3.6 Хашааны бэхэлгээ нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- буулгадаг хашааны нэмэлт баганад хөндлөвч утсыг хөдөлгөөнгүй бэхлэх ба үндсэн хашааны тулгуур шонд татсан хөндлөвч утастай нэг эгнээнд байна.
 - буулгадаг хашааны нэмэлт баганыг үндсэн хашааны шонгийн дээд ба доод хэсэгт утсан гогцоогоор бэхэлнэ.
 - дээд гогцоог сулласны дараа буулгадаг хашааг өргөж доод гогцооноос суллан буулгана.

8.4 ЭКОЛОГИЙН ХАШАА

- 8.4.1 Хашаа нь зэрлэг амьтдад ээлтэй, чөлөөтэй нэвтрэх боломжийг бий болгох зорилгоор мод, бут, сөөглөг ургамлыг дангаар болон хослуулан тарьж шигүү ургуулсан ургамлан хашаа байна.
- 8.4.2 Хашааны хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- экологийн хашааны өндөр 1000мм-ээс багагүй.
 - ургамлыг суулгах эгнээ нэг ба түүнээс дээш.
 - экологийн хашааны барилга, байгууламж, инженерийн шугамд ойртох зай, хэмжээ UCS 1410B:2022 Хашаа, хайс, хашлаганд тавих ерөнхий шаардлага стандартын заалтад нийцэх.
- 8.4.3 Хашааны материал нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- экологийн хашаанд харь зүйлийн бут, сөөг ашиглахгүй.

- экологийн хашааг бусад зэрлэг амьтдад ээлтэй хашаатай хослуулан тарьж болно.

9. ТУСГАЙ ШААРДЛАГА

- 9.1 Тусгай хамгаалалттай газар нутгийн зэрлэг амьтдад ээлтэй хашааны хөндлөвч утас нь зэрлэг амьтдыг хашаан дээгүүр харайх буюу доогуур мөлхөж нэвтрэхэд аюулгүй, орооцолдохгүй, гэмтэж бэртээхгүй байх, тод сайн харагдахуйц байна.
- 9.2 Зэрлэг амьтад орооцолдох өндөр эрсдэлтэй хашааны хамгийн дээд талын хөндлөвч төмөр утсыг уян тууз болон бусад материалаар бүрэх, гэрэл ойлгодог пайз зүүх, өндөр суналттай утас ашиглах зэргээр зэрлэг амьтдад ээлтэй, аюулгүй байдал болон харагдах байдлыг нэмэгдүүлнэ.
- 9.3 Хөдөлгөөнгүй болон буулгадаг хашааны шон, хөндлөвч зэрэг бүрдэл хэсгийн бүрэн бүтэн байдал, ойр орчим байрлуулсан тэмдэг, тэмдэглэгээнд тухайн газрыг эзэмшигч, өмчлөгч иргэн аж ахуйн нэгж хяналт тавьж энэ стандартын шаардлагыг хангах арга хэмжээ авна.
- 9.4 Хашааны ойр орчим зэрлэг амьтад орооцолдох, саад учруулах шон, төмөр утас болон бусад хог хаягдлыг зайлуулах арга хэмжээг авна.
- 9.5 Тусгай хамгаалалттай газар нутгийн зэрлэг амьтдад ээлтэй хашааны байршуулалт, ашиглалт, бүрэн бүтэн байдлыг 2-р хавсралтын дагуу шалгана.

10. ШАЛГАХ ХУУДАС

Улаанбаатар хотын зуслангийн бүсийн зэрлэг амьтдад ээлтэй хашааны шаардлагыг хангаж байгаа эсэхийг Хүснэгт 1-ийн дагуу хянан шалгана.

Хүснэгт 1. Шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Хашааны байршил 4-р бүлэгт заасан ерөнхий шаардлагыг хангасан эсэх	☐	☐
2	Зуслангийн бүсэд зэрлэг амьтдад ээлтэй хашааны байршил болон уртын хэмжээг тодорхойлох судалгаа, үнэлгээ хийсэн эсэх	☐	☐
3	Хашааны тулгуур шон, багана 5.1.2, 5.2.2-д заасан хэмжээг хангасан эсэх	☐	☐
4	Хашааны хөндлөвч 5.1.2, 5.2.2-д заасан хэмжээг хангасан эсэх	☐	☐
5	Хашааны материал 5.1.3, 5.2.3-т заасан шаардлагыг хангасан эсэх	☐	☐
6	Хашааны бэхэлгээ 5.1.4, 5.2.4-т заасан техникийн шаардлагыг хангасан эсэх	☐	☐
7	Хашааны суурь 5.1.5, 5.2.5-т заасан техникийн шаардлагыг хангасан эсэх	☐	☐
8	Экологийн хашаа 5.3-т заасан шаардлагыг хангасан эсэх	☐	☐
9	Хөндлөвч утасны бэхэлгээ суларсан, тасарсан эсэх	☐	☐
10	Хашааны тулгуур шон, тулах шон эвдэрсэн хугарсан эсэх	☐	☐
11	Хашааг зэрлэг амьтдад харагдахуйц байдлаар тоноглогсон эсэх	☐	☐
12	Хашааны ойр орчмын хог хаягдлыг зайлуулсан эсэх	☐	☐
13	Хашаа камерын системтэй эсэх	☐	☐
14	Хашаа гэрэлтүүлэгтэй эсэх	☐	☐
15	Хашаанд аюулгүй байдал, анхааруулах тэмдэг байрлуулсан эсэх	☐	☐
16	Хашааны шон, хөндлөвч бүрэн бүтэн эсэх	☐	☐
17	Галын аюул, онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөө, зааврын хэрэгжилт хангалттай эсэх	☐	☐

Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн зэрлэг амьтдад ээлтэй хашааны шаардлагыг хангаж байгаа эсэхийг Хүснэгт 2-ын дагуу хянан шалгана.

Хүснэгт 2. Шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Хашааны байршил 7-р бүлэгт заасан ерөнхий шаардлагыг хангасан эсэх	☐	☐
2	Зуслангийн бүсэд зэрлэг амьтдад ээлтэй хашааны байршил болон уртын хэмжээг тодорхойлох судалгаа, үнэлгээ хийсэн эсэх	☐	☐
3	Хашааны тулгуур шон 8.1.2, 8.2.2-д заасан хэмжээг хангасан эсэх	☐	☐
4	Хашааны хөндлөвч 8.1.2, 8.2.2-т заасан хэмжээг хангасан эсэх	☐	☐
5	Хашааны материал 8.1.2, 8.2.3-т заасан шаардлагыг хангасан эсэх	☐	☐
6	Хашааны бэхэлгээ 8.1.3, 8.2.4-т заасан техникийн шаардлагыг хангасан эсэх	☐	☐
7	Хашааны суурь 8.1.4, 8.2.5-т заасан техникийн шаардлагыг хангасан эсэх	☐	☐
8	Буулгадаг хашаа буюу гарц нь 8.3.1, 8.3.3-т заасан шаардлагыг хангасан эсэх	☐	☐
9	Экологийн хашаа 8.4-т заасан шаардлагыг хангасан эсэх	☐	☐
10	Хөндлөвч утасны бэхэлгээ суларсан, тасарсан эсэх	☐	☐
11	Хашааны тулгуур шон, тулах шон эвдэрсэн хугарсан эсэх	☐	☐
12	Хашааны зэрлэг амьтдад харагдахуйц байдлаар тоногдосон эсэх	☐	☐
13	Хашааны ойр орчмын хог хаягдлыг зайлуулсан эсэх	☐	☐
14	Хашаа камерын системтэй эсэх	☐	☐
15	Хашаа гэрэлтүүлэгтэй эсэх	☐	☐
16	Хашаанд аюулгүй байдал, анхааруулах тэмдэг байрлуулсан эсэх	☐	☐
17	Хашааны шон, хөндлөвч бүрэн бүтэн эсэх	☐	☐
18	Галын аюул, онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөө, зааврын хэрэгжилт хангалттай эсэх	☐	☐

Тайлбар: Дээрх шалгуур үзүүлэлтийг хангасан бол “Тийм” хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол “Үгүй” хэсгийг тэмдэглэнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- НҮБ-ын Биологийн олон янз байдлын тухай конвенц, 1992
- НҮБ-ын Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц, 1979
- Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, НИТХ, 2020
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, НИТХ, 2020
- Wingard, J., P. Zahler, R. Victurine, B. Onon, B. Buuveibaatar. 2014. Guidelines for Addressing the Impact of Linear Infrastructure on Migratory Ungulates in Central Asia. Convention on Migratory Species Technical Report, Bonn, Germany
- Paige, C. 2012. A Landowner's Guide to Fences and Wildlife: Practical Tips to Make Your Fences Wildlife Friendly. Wyoming Land Trust, Pinedale, WY. 52 pp
- Ministry of Agriculture, Food and the Environment. 2016. Technical prescriptions for wildlife crossing and fence design (second edition, revised and expanded). Documents for the mitigation of habitat fragmentation caused by transport infrastructure, number 1. Ministry of Agriculture, Food and the Environment. 124 pp Madrid
- Paige, C. 2020. Alberta Landholder's Guide to Wildlife Friendly Fencing. Alberta Conservation Association, Sherwood Park, Alberta. 68 pp
- Wyoming Game and Fish Dept. 2004. Fencing guidelines for wildlife. Revised versionHabitat Extension Bulletin No.53. Wyoming Game and Fish Dept. 12 pp.



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР



Хан-Уул дүүрэг, 23 дугаар хороо, Наадамчдын зам 1201,
Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор Б байр



72707700



www.uds.ub.gov.mn



Хот байгуулалт, хотын стандартын газар